



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/559.

Улаанбаатар хот

「Хан-Уул дүүргийн 144 дүгээр цэцэрлэгийн
эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,111,000.00 (нэг сая нэг зуун арван нэгэн мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Хан-Уул дүүргийн 336 дугаар цэцэрлэгт хавсралтын дагуу шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн 144 дүгээр цэцэрлэг (Л.Оюунцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 336 дугаар цэцэрлэг (Т.Болор)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150501704



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 00.00.00-ны 12... дугаар сарын 10...-ны өдрийн 000... дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 144 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалт- анд орсон он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ / төгрөгөөр /		Шилжүүлэн авах байгууллага
						нэгж үнэ	нийт үнэ	
Тавилга эд хогшил								
1	Хүүхдийн модон сандал	2011	дунд	ш	55	20,200.00	1,111,000.00	Хан-Уул дүүргийн 336 дугаар цэцэрлэг
Шилжүүлэх хөрөнгийн нийт дүн							1,111,000.00	